

ТАНИЛЦУУЛГА

“Тогтоол хүчингүй болгох тухай”
Засгийн газрын тогтоолын
төсөл боловсруулсан тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт “Ажилгүйдлийн даатгалын сангаас сургалтад хамрагдах нэг даатгуулагчид олгох зардлын дээд хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно” гэж заасан.

Энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Ажилгүйдлийн даатгалын сангаас сургалтад хамрагдах нэг даатгуулагчид олгох зардлын дээд хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 361 дүгээр тогтоолыг батлан мөрдөж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт ажилгүйдлийн даатгалын сангаас даатгуулагчид зөвхөн ажилгүйдлийн тэтгэмж, ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт олгохоор заасан.

Иймд ажилгүйдлийн даатгалын сангаас мэргэжлийн сургалтад хамруулахтай холбогдсон харилцааг зохицуулсан “Ажилгүйдлийн даатгалын сангаас сургалтад хамрагдах нэг даатгуулагчид олгох зардлын дээд хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 361 дүгээр тогтоолыг хүчингүй болгох шаардлагатай тул “Тогтоол хүчингүй болгох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулав.

Энэхүү тогтоолын төсөл батлагдсанаар ажил олгогч, даатгуулагч хууль тогтоомжийг нэг мөр ойлгож мөрдөх ба ямар нэг нэмэлт санхүүжилт шаардагдахгүй болно.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ